

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД
АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: АЙМГИЙН НӨӨЦ БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН

АУДИТ ХИЙСЭН
ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 онд баталсан "Аудитын сэдэв батлах тухай" А107, "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/108 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн хийж гүйцэтгэв.

АЙМГИЙН НӨӨЦӨӨС БЭЛТГЭСЭН 177.2 САЯ ТӨГРӨГИЙН ТЭЖЭЭЛИЙН ХУГАЦАА
ДУУССАН, 293.6 САЯ ТӨГРӨГИЙН АВЛАГЫГ БАРАГДУУЛААГҮЙ БАЙНА

ТАЙЛАНГ ХҮРГҮҮЛСЭН:

Ховд аймгийн Засаг дарга, Иргэдийн хурал, Засаг даргын тамгын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Сумдын засаг дарга.

Ховд хот

2025 оны 12 дугаар сар

АУДИТЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Аудитын хураангуй тайлангийн зорилго, зорилтууд, хамарсан хүрээ

“Аймгийн нөөц хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэнэ.

Аудитад аймаг, сумдын Засаг дарга болон СТСХ, БОНХОБТХ, Аймгийн Онцгой комисс, ХХААГ, Мал эмнэлгийн газар зэрэг байгууллагуудын аймаг, сумын нөөц бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалттай холбоотой баримт материал, аймгийн орон нутгийн нөөц хөрөнгийн зарцуулалт, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой 2023-2024 оны үйл ажиллагааг хамруулав.

Аймаг, сумуудын өвс тэжээлийн тооцоог 2025 оны хагас жилээр тасалбар болгон зарцуулалтыг хяналаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар сумдын Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалттай холбоотой эрсдэл бага тул аудитад хамруулаагүй, харин нөөцийн бүрдүүлэлт, зарцуулалттай холбоотой авлагын үлдэгдлийг өмнөх онуудаас хөөн тулган баталгаажуулсан.

Хуулийн байгууллагад шалгагдаж байгаа асуудлыг аудитаар авч үзээгүй болно

Аудитын зорилго, зорилтууд

Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Аймгийн нөөцийг хэрэгцээ шаардлагад үндэслэн бүрдүүлсэн үү?
- Аймгийн нөөцийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулж байна уу?
- Нөөц бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй байна уу?

Аудитын хүндрэл бэрхшээл

Аудитын явцад төсвийн ерөнхийлөн захирагч, зарим ажил хариуцсан албан хаагч солигдсон, төрийн байгууллагуудын ажил хариуцаж байгаа зарим мэргэжилтнүүдийн ажилдаа хандах хандлага сул, холбогдох мэдээ мэдээллийг цагт нь ирүүлдэггүй, хариуцсан ажлын талаарх дэлгэрэнгүй тоо мэдээ, судалгаа бүрэн бус, архивын нэгж үүсээгүй, зарим төсөл арга хэмжээг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжээс санал тайлбар авахад бэрхшээл үүссэн зэрэг асуудлууд аудитыг гүйцэтгэхэд хүндрэлтэй байлаа.

Бүлэг1. Аймгийн нөөцийг бүрдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг төлөвлөөгүй, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна

Аймгийн нөөц бүрдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг төсөвт төлөвлөөгүй, худалдан авах ажиллагааг зохион байгуулахгүйгээр 452.8 сая төгрөгийн нөөц бэлтгэжээ

1.1 Монгол улсын Засгийн газрын 2023 оны 344 дүгээр тогтоолоор баталсан стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журамд “аймаг, нийслэлийн Засаг дарга нь тогтоосон тоо хэмжээний нөөцийг бүрдүүлэхэд шаардагдах санхүүжилтийг орон нутгийн тухайн жилийн төсөвт тусгуулах арга хэмжээг авна” гэж журамласан байна.

1.2 Аймгийн Засаг дарга мах болон шатахууны нөөц бүрдүүлэхэд шаардагдах төсвийг орон нутгийн төсөвт тусгахгүйгээр барьцаа хөрөнгийн данснаас 2023 онд махны нөөц бүрдүүлэхэд 1,200.0 сая, шатахууны нөөц бүрдүүлэхэд 1,000.0 сая төгрөг, 2024 онд махны нөөц бүрдүүлэхэд 1,140.0 сая төгрөгийг төсөвт зохицуулалт хийж бүрдүүлжээ.

1.3 Харин өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах хүрээнд өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд зарцуулах санхүүжилтийг орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт нийт дүнгээр 2023 онд 300.0 сая төгрөг, 2024 онд 714.0 сая төгрөгөөр тус тус төлөвлөн баталжээ.

1.4 Аймгийн нөөц бүрдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг төсөвт төлөвлөөгүй, нийт дүнгээр баталж байгаа нь нөөцийг хэзээ, хэрхэн бэлтгэх нь тодорхой бус, нөөц бэлтгэх үйл ажиллагааг хууль журмын дагуу хэрэгжүүлэхэд хүндрэл үүссэн, улмаар онцгой комиссын шийдвэр гарган худалдан авах ажиллагааг зарлахгүйгээр шууд гэрээ байгуулан бэлтгэсэн нь холбогдох хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

1.5 Төсвийн ерөнхийлөн захирагч нь жил бүрийн төсвийн багцдаа гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, зардлыг тусгах чиг үүргийн дагуу Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилтийн дүнг Сангийн яамнаас 2023 онд 1,230.0 сая төгрөгөөр, 2024 онд 494.4 сая төгрөгөөр хянасан байхад аймгийн ИТХ-аас 2023 онд 1,078.9 сая төгрөгөөр, 2024 онд 1,000.0 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

1.6 Аймгийн ИТХ-аас Засаг даргын нөөц хөрөнгийн 2024 онд санхүүжих дүнг сангийн яамны хянасан дүнгээс 504.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн батлахдаа тооцоо судалгаагүй, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэсэн байна.

1.7 Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилтийг ковидын цар тахал үүссэнтэй холбоотой 2021, 2022 онуудад нэмэгдүүлэн 732.2 сая төгрөгөөр баталсан бөгөөд төсөв захирагчаас 2023, 2024 онуудад бууруулахгүйгээр өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байгаа нь төсөвлөлтийн шаардлага хангахгүй байна.

1.8 Ховд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилтэд төлөвлөсөн дүнг баруун бүсийн аймгуудын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар баталсан нөөц хөрөнгийн дүнтэй харьцуулахад бүсийн дунджаас 2023 онд 562.9 сая төгрөгөөр, 2024 онд 253.8 сая төгрөгөөр өндөр байгаа нь төсөв захирагчаас нэмэгдсэн төсвийг бууруулахгүйгээр нөөц хөрөнгийн журамд нийцээгүй хүрэлцэхгүй байгаа зарим зардлыг төлөвлөн санхүүжүүлж ирсэнтэй холбоотой байна.

1.9 Засгийн газрын 2023 оны 344 дүгээр тогтоолоор стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журам батлагдаж, аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ хүн амыг стратегийн хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах, улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд дагаж мөрдөхөөр журамласан ч журмын хэрэгжилтийг хангах талаар ямар нэгэн арга хэмжээ аваагүй, мэдээ тайланг холбогдох газарт хүргүүлж ажиллаагүй байна.

1.10 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай

хуулийн 31.1¹-т заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах, Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх журмын 2.4-д “Аймаг нийслэлийн Засаг дарга нь тухайн орон нутгийн нөөц бэлтгэх боломжтой бэлтгэн нийлүүлэгчтэй холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн сонгон шалгаруулалтын үндсэн дээр гэрээ байгуулан нөөц бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна ” гэж тус тус заасан байна.

1.11 Аймгийн Засаг дарга нөөц бүрдүүлэхэд зориулж 2023 онд 2,657.6 сая төгрөг, 2024 онд 1,298.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулсан ч худалдан авах ажиллагааг зохион байгуулахгүйгээр, аймгийн онцгой комиссын шийдвэрээр бэлтгэн нийлүүлэгчтэй шууд гэрээ байгуулсан байна.

1.12 Махны нөөцийг бэлтгэхдээ аймгийн хэмжээнд мах бэлтгэх, махан бүтээгдэхүүн боловсруулах чиглэлийн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн хүсэлт, хүчин чадал зэрэгт үндэслэн санхүүжилтийг тэнцүү байдлаар хуваарилан шууд гэрээ байгуулан зохион байгуулсан байна.

1.13 Аймгийн аюулгүй нөөцөд чанартай, хямд өвс бэлтгэх зорилгоор хадлангийн бүс нутаг болох Буянт, Мянгад сумын хадлан бэлтгэдэг иргэдтэй шууд гэрээ байгуулан аймаг, сумдын нөөц бүрдүүлжээ.

1.14 Аймгийн онцгой комисс нь гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүсээгүй байхад ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.1.5² дахь заалтыг баримтлан 2023 онд 400 тонн хүртэл тэжээл, 394.5 сая төгрөгийн өвс, тэжээл бэлтгэхдээ шууд гэрээ байгуулахыг зөвшөөрсөн тогтоолыг гаргасан нь холбогдох хууль журмыг зөрчсөн тул албан шаардлага тогтоолоо.

✓ *Аймгийн нөөцийг бэлтгэхдээ тендер шалгаруулалт зохион байгуулаагүй, хуульд нийцээгүй онцгой комиссын шийдвэр гарган шууд гэрээ байгуулан 2023 онд 376.8 сая төгрөг , 2024 онд 76.0 сая төгрөгийн тэжээл бэлтгэсэн.*

1.15 Аймгийн нөөц бүрдүүлэлттэй холбоотой онцгой комиссын тогтоол, шийдвэрийг тулган хянахад 2023 онд 7 тогтоол гаргаснаас 3, 2024 онд 10 тогтоол гаргаснаас 9 нь хурлын тэмдэглэлээр баталгаажаагүй зөрчил илэрлээ.

1.16 Сонгон шалгаруулалтгүйгээр аймгийн аюулгүйн нөөцөд тэжээл бэлтгэснээр хэрэгцээ шаардлагад нийцээгүй, хугацаа дууссан, хэрэглэж хэвшээгүй тэжээл нийлүүлэгдэх, төсвийн үрэлгэн зардал гарах эрсдэл үүсэж байгаа тул зөрчлийг таслан зогсоох шаардлагатай байна.

1.17 Аймгийн Засаг дарга өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, иргэдийн хүнсний хэрэгцээг хангах, үнийг тогтворжуулах, шатахууны хомсдолоос сэргийлэх зорилгоор 2023-2024 онд 4 төрлийн нөөцийг бэлтгэсэн байна

¹ Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсвөт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийг дагуу зохион байгуулна:

² гамшгийн онц нөхцөл байдал зарласан, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол;

БҮЛЭГ 2. Бэлтгэсэн нөөцийн авлага барагдуулж, эргэлтийг сайжруулан 474.0 сая төгрөгийн төсвийн үр өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна

Иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн махны нөөц бэлтгэсэн ч нийлүүлсэн махны хэмжээ жилээс жилд буурснаар дэвшүүлсэн зорилтыг хангаагүй байна

2.1 Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журамд бэлтгэсэн нөөцийг стандартын шаардлага хангасан байр бүхий тухайн орон нутгийн хүнсний чиглэлийн худалдаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан худалдах замаар зарцуулалтыг зохион байгуулна гэж заажээ.

2.2 Аймгийн хэмжээнд бүрдүүлсэн махыг Жаргалант сумын 12 багийн нутаг дэвсгэрт байрлаж байгаа 25 дэлгүүр, бэлтгэн нийлүүлэгчдийн махны үйлдвэрээр борлуулахаар зохион байгуулжээ.

Хүснэгт 1. Махны нөөцийн борлуулалтын судалгаа (кг-аар)

ААН нэр	Нийт борлуулах			Үйлдвэрээр борлуулсан			Дэлгүүрээр борлуулсан		
	Гэрээ	Гүйцэтгэл	Хувь	Гэрээ	Гүйцэтгэл	Хувь	Гэрээ	Гүйцэтгэл	Хувь
Баруун монгол интернейшнл ХХК	25,570	24,740	97	12,785	23,400	183	12,785	1,340	10
Хан жаргалант хоршоо	25,570	20,500	80	12,785	11,000	86	12,785	9,500	74
Алтайн Мийт ХХК	25,570	24,378	95	12,785	13,300	104	12,785	11,078	87
Жаргалант шанд ХХК	25,570	25,533	100	12,785	11,370	89	12,785	14,163	111
Ирмүүн чандмань ХХК	25,570	17,393	68	12,785	8,230	64	12,785	9,163	72
Иов ХХК	17,950	9,485	53	8,975	1,572	18	8,975	7,913	88
2023 оны дүн	145,800	122,029	84	72,900	68,872	94	72,900	53,157	73
Жаргалант шанд ХХК	26,071	0	-	10,428	0	-	15,642	0	-
Баян нутгийн өгөөж ХХК	7,142	5,186	73	2,856	3199	112	4,285	1,987	46
Хан жаргалант хоршоо	32,589	13,309	41	13,035	3257	25	19,553	10,052	51
Ирмүүн чандмань ХХК	23,464	9,711	41	9,385	1490	16	14,078	8,221	58
Алтайн Мийт ХХК	26,071	10,728	41	10,428	1027	10	15,643	9,701	62
"Мөнх гэгээн жаргалант" ХХК	19,553	12,540	64	7,821	2580	33	11,732	9,960	85
"Төв цагаан морь" ХХК	22,160	19,459	88	8,864	4389	50	13,296	15,070	113
2024 оны дүн	157,050	70,933	45	62,820	15942	25	94,230	54,991	58

2.3 Нөөцийн махны борлуулалт 2023 онд 122,029 кг буюу 84 хувь, 2024 онд 70,933 кг буюу 45 хувьтай байгаа нь иргэдийг эрүүл ахуйн шаардлага хангасан хямд үнэтэй махаар хангах, махны үнийг тогтворжуулах зорилтоо бүрэн хангаагүй байна.

2.4 Гэвч нөөцийн махны үнийг тухайн үеийн зах зээлийн ханштай жишиж тооцоход 2023 онд 650.4 сая, 2024 онд 462.3 сая төгрөгийн бодит эдийн засгийн хэмнэлт иргэдийн амьдралд бий болж, хүн амын хүнсний хүртээмжийг нэмэгдүүлсэн үр нөлөөтэй арга хэмжээ байна.

Хүснэгт 2. Нөөцийн махны үр ашиг тооцсон байдал

Он	Зах зээлийн үнээс тооцсон зөрүү үнэ		Борлуулсан хэмжээ /кг/		Хэмнэлт (сая.төг)
	Хонь	Ямаа	Хонь	Ямаа	
2023	6,550	3,125	78,580	43,449	650.5
2024	7,750	3,707	49,301	21,632	462.3
Дүн	14,300	6,832	127,881	65,081	1,112.7

2.5 Дэлгүүрээр борлуулсан нөөцийн махны санхүүгийн баримтыг баталгаажуулан борлуулалтыг хянасан ч үйлдвэрээр борлуулсан нөөцийн махыг санхүүгийн баримтаар баталгаажуулаагүй, гэрээнд заасан хугацаанд нөөцийн махыг борлуулсныг нотлох баримт байхгүй нь иргэдэд нөөцийн махыг бүрэн хүргэсэн эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

2.6 Нөөцийн махны санхүүжилтийг мах бэлтгэлийн хугацаанд өгөөгүйгээс махыг өндөр үнээр бэлтгэх, махны чанарыг бууруулах эрсдэл үүссэн, бэлтгэн нийлүүлэгчээс нөөцийн махыг үр ашигтай бэлтгэх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэжээ.

2.7 2024 онд нөөцийн махыг үр ашигтай бэлтгэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор гэрээнд 2 заалтыг нэмж тусгасан, Эвийн хүч худалдааны төв дээр гулуузаар худалдаалах нэгдсэн цэг гаргаж ажиллуулсан байна.

2.8 Аймгийн хэмжээнд 2024 оны байдлаар 13 мах төхөөрөх үйлдвэр бүртгэлтэй байгаагаас шаардлага хангасан 8 үйлдвэр хүнсний тухай хууль болон хүнсний аюулгүй байдлын тухай хуулийн дагуу аймгийн Мал эмнэлгийн газраас үйл ажиллагаа явуулах дүгнэлт авчээ.

2.9 Гэвч аймгийн Засаг дарга 2024 онд шаардлага хангаагүй 2, 2025 онд 3 аж ахуйн нэгжээс мах бэлтгэхээр гэрээ байгуулсан нь холбогдох хуульд нийцэхгүй байна.

2.10 Аймгийн аюулгүй нөөцөд бэлтгэсэн өвс тэжээлийг цас зудын нөхцөл байдал болон сумдаас ирүүлсэн саналыг үндэслэн онцгой комиссын хурлаар хэлэлцүүлэн, Засаг дарга Захирамж гарган 2023 онд 17 суманд 429.5 сая төгрөгийн, 2024 онд 5 сумын 181.6 сая төгрөгийн өвс тэжээлийг хуваарилжээ.

2.11 Дээрх хуваарилсан тэжээлээс хувь иргэнд хөнгөлөлттэй үнээр 2023 онд 80.5 сая төгрөгийн, 2024 онд 32.3 сая төгрөгийн өвс тэжээлийг олгосон нь авлагын тооцоо хийхэд хүндрэл үүсгэсэн, хуваарилалтын талаар гаргасан захирамж шийдвэрийг зөрчиж байгаа тул зөрчлийг арилгуулах албан шаардлага тогтоолоо.

2.12 Аймгийн ЗДТГ нь хадлангийн механикжсан салааны тоног төхөөрөмжийг түрээсээр эзэмшүүлсний төлбөрт ногдох өвсийг аймгийн өвсний фондод хүлээлгэж өгөхөөр гэрээнд заасан байхад өвсийг татан авах тээврийн зардалд 2023 онд 8.6 сая төгрөг, 2024 онд 11.3 сая төгрөг, нийт 19.9 сая төгрөгийн үрэлгэн зардал гаргажээ.

2.13 Бэлтгэсэн өвс, тэжээлийн чанар, аюулгүй байдлыг хангахын тулд сэлгэх арга хэмжээг оновчтой зохион байгуулаагүй, эхэлж авснаа эхэлж зарлагадаагүй, нөөцийн хөдөлгөөнийг бүртгээгүй зэргээс шалтгаалан 2023 онд Алтай сум 6.4 сая төгрөгийн хугацаа дууссан тэжээлийг иргэдэд үнэгүй олгосон, 2024 онд 45.7 сая төгрөгийн, 2025 оны хагас жилийн байдлаар 73.2 сая төгрөгийн тэжээлийн хугацаа дуусаж агуулахад хадгалагдаж байгаа, 51.9 сая төгрөгийн тэжээлийг акталж, нийт 177.2 сая төгрөгийн төсөвт үргүй зардал гарчээ. Үүнд:

- ✓ Алтай сум 2023 онд 100 уут хорголжин тэжээл, 166 уут гурилан тэжээлийн хадгалах хугацаа дууссан тул иргэдэд үнэгүй олгосон, 2024 онд 520 уут гурилан тэжээл хадгалах хугацаа дууссан агуулахад хадгалагдаж байгаа,
- ✓ Аудитын явцад аймгийн ЗДТГ-ын агуулахын үлдэгдлийг тулган шалгахад 2.2 сая төгрөгийн хүчит тэжээл, 43.7 сая төгрөгийн цеопид, 27.5 сая төгрөгийн хорголжин тэжээлийн хугацаа дууссан,
- ✓ 2024 онд өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсгийн шалгалтаар Зэрэг сум 16.5 сая төгрөгийн 1000 уут хивгэн тэжээл, Чандмань сум 10.0 сая төгрөгийн 8 тн хорголжин тэжээлийн хугацаа тус тус дууссан зөрчил илэрсэн,
- ✓ Ховд сумын агуулахад 11.2 сая төгрөгийн эрдэнэ шишийн дарш хугацаа дууссан
- ✓ Жаргалант сумын агуулах аймгийн аюулгүй нөөцөөс хуваарилсан 2.9 сая төгрөгийн тэжээлийн хугацаа дууссан хадгалагдаж байгаа,
- ✓ Эрдэнэбүрэн сумын агуулахад 2024 оны 5.0 сая төгрөгийн тэжээлийн хугацаа дууссан,

2.14 Жаргалант, Манхан, Мөнххайрхан сумууд өвс тэжээлийн тооцоог хийж, бүртгэлд бүрэн тусган, анхан шатны баримтыг бүрдүүлж, авлагын барагдуулалтыг тухай бүр хийж хэвшсэн байна.

2.15 Аймаг, сумдын ЗДТГ нь аймгийн аюулгүйн нөөцөөс хуваарилсан өвс тэжээлийг бүртгэлд тусгаагүй, өглөг, авлагын тооцоо нийлж баталгаажуулаагүй, орлогыг төсөвт бүрэн

төвлөрүүлээгүй, урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан зэрэг нийтлэг зөрчил илэрлээ. Үүнд:

- ✓ Аймгийн ЗДТГ нь 2023 онд Булган сумын механикжсан салааны 4000 пресс өвсийг орлого авч, бүртгэлд тусгаагүй, 27.2 сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй,,
- ✓ Аймгийн ЗДТГ нь Булган сумын механикжсан салаанаас 2023 онд 4000 пресс өвсийг бэлтгэж Алтай, Булган, Үенч сумуудад олгож, татан авах зардлыг төлсөн ч тус өвсийг орлогод авч бүртгээгүй, тооцоо хийгээгүй,
- ✓ Аймгийн ЗДТГ 2023 онд Алтан хөхийн угалз ХХК-аас 5000 ширхэг пресс өвс, Аж мандалд ХХК-аас 2000 уут тэжээл хүлээн авах ажил комиссын актыг хүлээн авсан дүнгээс зөрүүтэй үйлдсэн,
- ✓ Булган сум 2024 онд ОНХС-ийн санхүүжилтээр бэлтгэсэн 1284 пресс өвсийг онцгой комиссын шийдвэргүйгээр иргэдэд үнэгүй олгосон,
- ✓ Дарви сум 2023 онд иргэдэд олгосон өвс тэжээлийн 7.4 сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй,
- ✓ Дуут сум 2024 онд борлуулсан өвс тэжээлийн орлогоос 3.2 сая төгрөгийн орлогыг тооцоо нийлсэн боловч төсөвт дутуу төвлөрүүлсэн,
- ✓ Үенч сум бэлтгэсэн өвс тэжээлийн тооцоо хийж авлагад бүртгээгүй, 2023 онд 1.2 сая, 2024 онд 2.3 сая төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн,
- ✓ Үенч сум 2023 онд 3.3 сая төгрөг, 2024 онд 1.7 сая төгрөгийн өвс тэжээлийн орлогыг байгууллагын үйл ажиллагаа болон зориулалт бусаар зарцуулсан
- ✓ Мөст сум 3.0 сая төгрөгийн өвс, тэжээлийн орлогыг байгууллагын үйл ажиллагаа болон зориулалт бусаар зарцуулсан,
- ✓ Эрдэнэбүрэн сум 2023 онд бэлтгэсэн 125 ширхэг тэжээлийг тушаал шийдвэргүй акталсан,
- ✓ Эрдэнэбүрэн сумын ЗДТГ нь 2024 онд өмнөх оны үлдэгдэл прессийг хямдралтай үнээр борлуулсан ч 5.6 сая төгрөгийн орлогыг хувь хүний дансаар авч, төсөвт төвлөрүүлээгүй,
- ✓ Цэцэг сумын ЗДТГ нь 2024 онд иргэдэд олгосон тэжээлийн тооцоог авлагаар бүртгээгүй, 5.5 сая төгрөгийн төсөвт төвлөрүүлээгүй,

2.16 Бүрдүүлсэн шатахууны нөөцөөс 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын хариу арга хэмжээнд малчид ард иргэдэд зам гаргах, хоол хүнс, шатахуун, өвс тэжээл хүргэх зардалд 206.1 сая төгрөг, Булган, Үенч, Алтай сумуудад 2024 оны 12 сард мал вакцинжуулах, өвөлжилт хүндэрсэнтэй холбоотой ажилд 109.2 сая төгрөгийн шатахууныг зарцуулж, үлдэгдэл 20.1 сая төгрөгийг орон нутгийн хөрөнгө оруулалтын дансанд төвлөрүүлсэн байна.

2.17 Дээрх зарцуулсан шатахуунаас аймгийн ЗДТГ нь 44.2 сая төгрөгийн шатахууныг зарцуулсан бөгөөд үүнээс 26.6 сая төгрөгийн шатахууныг Онцгой байдлын газар, Цэргийн анги, Бүсийн эмчилгээ оношилгооны төвд шилжүүлж, үлдэгдэл 17.6 сая төгрөгийн шатахууныг аймгийн ЗДТГ нь өвөлжилт, хаваржилтын болон дотоод үйл ажиллагаанд зарцуулсан байна.

2.18 Аймгийн ЗДТГ-ын зарцуулсан шатахууныг хянахад 11.4 сая төгрөгийг шатахууныг зориулалтын дагуу зарцуулаагүй, анхан шатны баримт дутуу, тооцоо бодоогүй зөрчил илэрч албан шаардлага тогтоов.

2.19 Оюу мандал ХХК-тай байгуулсан шатахууны нөөц бүрдүүлэх ажлын гэрээнд заасны дагуу аймгийн нөөцөд нийт А92 бензин 161.5 тонн, дизель түлш 111.2 тонныг нийлүүлэхээр заасан ч нөөцөлсөн шатахууныг хэрхэн борлуулсан, зах зээлд 50-100 төгрөгөөр хямд үнээр

Хүснэгт 3. Нөөцөөс зарцуулсан шатахуун

Д/Д	Байгууллагуудын нэрс	Мөнгөн дүн (сая.төг)
1	Алтай сумын ЗДТГ	15.7
2	Булган сумын ЗДТГ	18.6
3	Үенч сумын ЗДТГ	19.7
4	Аймгийн ЗДТГ	44.2
5	Онцгой комисс	9.1
6	Булган сум дахь Цагдаагийн тасаг	0.9
7	Баруун 3 суманд мал вакцинжуулах,	109.2
Дүн	Нийт мөнгөн дүн	217.4

нийлүүлсэн талаарх тайлан мэдээ байхгүй, гэрээг дүгнээгүй тул гэрээний үр дүнг тооцох боломжгүй байна.

Засаг даргын нөөц хөрөнгөд журамд нийцээгүй төсөвт төлөвлөх боломжтой зардлыг төлөвлөсөн, бүртгэлээр тавих хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна

2.18 Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журамд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ, зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхээр зохицуулсан байна.

2.19 Засаг даргын нөөц хөрөнгийг аймгийн ИТХ-ын 2023 оны 12/02 тоот тогтоолоор 1,078.9 сая, 2024 оны 18/02 тоот тогтоолоор 1,000.0 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 2023 онд 942.8 сая, 2024 онд 980.4 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

2.20 Засаг даргын нөөц хөрөнгийн журмын 2.1.1³ дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбоотойгоор 2023-2024 онуудад цас зуд, үер ус, халдварт шүлхий өвчин зэрэг онц нөхцөл байдал үүссэн, мөн урьдчилан сэргийлэх үүднээс гамшгийн эсрэг сургалт, бэлэн байдал хангах зэрэгт нийт зарцуулалтын 13 хувь буюу 255.2 сая төгрөгийг зарцуулжээ

2.21 Орон нутгийн нөөц хөрөнгийн зарцуулалтыг зориулалтаар нь авч үзэхэд Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5⁴ - дэх заалтыг баримтлан 2023 онд 68 хувь 639.6 сая төгрөг, 2024 онд 67.5 хувь буюу 662.0 сая төгрөг зарцуулжээ.

Хүснэгт 4. Зардлын зориулалт

№	Зардлын зориулалт	2023 он	2024 он
1	Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа	255.2	165.5
2	Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд	19.3	16.2
3	Байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх;	10.0	70.0
4	Урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй, нэг удаагийн шинжтэй	639.6	662
5	Шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг.	18.7	66.7
	Нийт	942.8	980.4

2.22 Нийт зарцуулалтын ихэнх хувийг эзэлж байгаа урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй, нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зарцуулсан зардалд хүлээн авалт, бэлэг дурсгал 2023 онд 114.8 сая төгрөг, 2024 онд 169.8 сая төгрөг, тоног төхөөрөмж, аж ахуйн материал бэлтгэхэд 2023 онд 225.6 сая төгрөг, 2024 онд 123.8 сая төгрөг, баяр наадмын зардалд 2023 онд 27.5 сая төгрөг, 2024 онд 113.2 сая төгрөг зарцуулсан нь ихэнх хувийг эзэлж байна.

2.23 Зардлын гүйцэтгэлийг хянахад тогтмол гардаг, төлөвлөх боломжтой 27.1 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага тогтоолоо. Үүнд:

- Баруун бүсийн зөвлөлөөс Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумыг шагнасан 5 сая төгрөг
- Чандмань сумын Талын булаг багийн худгийн засварт 5.0 сая төгрөг,
- Галдан бошгот, Аймгийн Хүндэт тэмдэг, Ховдын төлөө медаль, уран зургийн жааз зэрэгт 85.9 сая төгрөг зарцуулсан,
- 2023 , 2024 онуудад нийт 14 Засаг даргын захирамжийн дүнгээс хэтрүүлэн зарцуулсан 17,100.1 мянган төгрөг,

³ хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин, хортон мэрэгчид тархах зэрэг байгалийн гамшигт үзэгдэл тохиолдсон, ;

⁴ энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ;

2.24 Солонгос, Хятад улс руу 2 удаагийн гадаад айлчлал, сургалтад оролцох зардлыг нярвын дансаар дамжуулж зарцуулсан ч анхан шатны баримтгүй, тооцоо бодоогүй, буудлын төлбөрийн бүрдүүлсэн анхан шатны баримт хангалтгүй, шатахууны тооцоо бүрэн бодоогүй, жолоочийн тооцооны хуудас дутуу, дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй зэргээс үзэхэд бүртгэлд тавих дотоод хяналт сул байна.

2.25 Нөөц хөрөнгийг зарцуулахдаа Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэхээр журамласан ч 2023 онд 14.8 сая төгрөгийн Алтан Хөхий уулын тэнгэрийг тайх төрийн тахилгын ёслолын арга хэмжээнээс бусад зардлыг зөвлөлөөр хэлэлцүүлээгүй, 2024 оны Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэр гарсан нь тодорхойгүй, журмын хэрэгжилт хангагдаагүй байна.

2.26 Нөөц хөрөнгийн зарцуулалтын тайланг санхүүжүүлсэн зардал, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсөвтэй зэрэгцүүлэн гаргахгүй байгаа нь захирамжийн дүнгийн хэтрүүлэх, хэмнэлтийг төсөвт буцаан төвлөрүүлэхгүй байх эрсдэл үүсгэжээ. Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 3.4-т ⁵заасны дагуу хохиролд зарцуулагдаагүй үлдэгдлийг Засаг даргын нөөц хөрөнгийн дансанд бэлэн байршуулаагүй байна

2.27 Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын тодорхойгүй заалтууд нь хэрэгжилт хангагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна. Үүнд:

Хүснэгт 5. Засаг даргын нөөц хөрөнгийн зөрчилтэй заалт

Журмын заалт	Зөрчилтэй заалт
2.1.5. журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ;	Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой гэж заасан ч төлөвлөх боломжтой зардлыг санхүүжүүлэх боломжийг бүрдүүлсэн, агуулга давхардсан
3.4. Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг зарцуулах ба хохиролд зарцуулагдаагүй үлдэгдлийг сарын хуваариас тооцоолж Засаг даргын нөөцөд бэлэн байршуулсан байна.	Энэ заалт нь батлагдсан нийт дүнгээс эсвэл сарын батлагдсан дүнгээс 30 хувийг байршуулах эсэх нь тодорхой бус, агуулга тодорхой бус,
3.5 Энэ журмын 3.4-д заасан хохиролд зарцуулагдаагүй үлдэгдлийг тухай оны эцэст энэ журамд заасан зориулалтын дагуу зарцуулж болно.	Бусад зардалд онцгой тохиолдолд зарцуулах зардлын бусад зардлуудад зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн,

2.28 Нөөц хөрөнгийн зарцуулалтын тайланг санхүүжүүлсэн зардал, арга хэмжээ бүрээр гаргаж байгууллагын нягтлан бодогч тооцоо бодож, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах шаардлагатай байна.

Аймаг сумдын ЗДТГ нь бүрдүүлсэн нөөцийн авлага, өглөгийн тооцоо нийлээгүй, өмнөх онуудын 296.8 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна

⁵ “Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг зарцуулах ба хохиролд зарцуулагдаагүй үлдэгдлийг сарын хуваариас тооцоолж Засаг даргын нөөцөд бэлэн байршуулсан” байна.

2.29 Аймгийн ЗДТГ нь нөөц бүрдүүлэхтэй холбоотойгоор 2023 онд 19 гэрээ, 2024 онд 13 гэрээ байгуулан ажиллажээ. Дээрх байгуулсан гэрээнүүдээс шатахууны нөөц бүрдүүлэх гэрээг дүгнээгүй бөгөөд бусад гэрээг дүгнэн, холбогдох тооцоог хийсэн байна.

2.30 Оюу мандал ХХК-тай байгуулсан байгуулсан шатахууны нөөц бүрдүүлэх гэрээ нь байгуулсан он сар өдөр тодорхой бус, гэрээний дугааргүй, нийлүүлэх шатахууны хэмжээг алдаатай тусгасан, гэрээг дүгнэлгүйгээр хугацаа дуусахаас өмнө Засаг даргын 2024 оны А/823 дугаар захирамжаар үндэслэлгүй сунгасан зөрчил илэрсэн тул авлагыг барагдуулах албан шаардлага тогтоолоо.

2.31 Махны нөөц бүрдүүлэх гэрээг 2023 онд гэрээний шалгуур үзүүлэлтээр дүгнэсэн ч 2024 онд нарийвчлан дүгнээгүй, 2024 оны гэрээний 7.3-т “Гэрээний хугацаа дуусмагц захиалагчийн ажлын хэсэг болон нийлүүлэгч хамтран дүгнэх бөгөөд 80 хувиас доош дүгнэгдсэн нь дахин гэрээ байгуулахгүй байх үндэслэл болно” гэж заасан ч 2025 оны нөөцийн мах бэлтгэх гэрээ байгуулахдаа 80 хувиас доогуур үнэлэгдсэн 2 аж ахуйн нэгжид хамгийн өндөр санхүүжилтийг олгохоор гэрээ байгуулсан байна

2.32 Аймгийн хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар өвс, тэжээлийн 296.8 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаагаас 92 хувь буюу 273.3 сая төгрөгийн авлага аймгийн ЗДТГ-ын тайланд, үлдэгдэл 8 хувь буюу 23.5 сая төгрөгийн авлага Манхан, Мөнххайрхан, Мөст сумуудын ЗДТГ-ын тайланд тус тус бүртгэлтэй байна.

2.33 Аймгийн ЗДТГ нь 2024 онд өвс, тэжээлтэй холбоотой авлагын тооцоо нийлж акт үйлдээгүй, авлага барагдуулах арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулаагүй 273.3 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлага байна.

Хүснэгт 6. Авлагын насжилт

д/д	Харилцагчид	Авлагын дүн	Авлагын насжилт		
			0-1 жил	1-2 жил	3-дээш жил
1	Эко Ховд ХХК	43.7	-	-	43.7
2	Ховд агро парк ТӨОХХК	23.8	-	23.8	-
3	Дөргөн хярын улаан ХХК	7.0	-	-	7.0
4	Дарви ЗДТГ	27.0	-	7.4	19.5
5	Мянгад ЗДТГ	6.0	-	-	6.0
6	Цэцэг ЗДТГ	1.5	-	-	1.5
7	Булган ЗДТГ	12.8	12.8	-	-
8	Зэрэг ЗДТГ	8.7	-	0.6	8.1
9	Эрдэнэбүрэн ЗДТГ	10.2	-	4.1	6.1
10	Мөнххайрхан ЗДТГ	13.2	-	2.9	10.4
11	Алтай ЗДТГ	22.5	16.6	5.9	-
12	Буянт ЗДТГ	0.1	-	-	0.1
13	Дуут ЗДТГ	23.7	-	7.4	16.2
14	Мөст ЗДТГ	9.1	3.3	-	5.8
15	Чандмань ЗДТГ	24.0	6.3	-	17.7
16	Үенч ЗДТГ	15.4	10.9	-	4.4
17	Манхан ЗДТГ	2.9	-	2.9	-
18	Жаргалант ЗДТГ	11.2	-	1.2	10.0
19	Иргэдээс (6 хүн)	10.6	3.8	2.6	4.2
	Дүн	273.3	53.7	58.8	160.7

2.34 Бүртгэлтэй авлагыг насжилтаар нь авч үзвэл 24.5 хувь нь 1 жил хүртэл, 21.5 хувь нь 1-2 жил, 54.3 хувь нь 3-аас дээш жилийн насжилттай байна.

2.35 Аймгийн ОНХС-ын 2024 оны санхүүгийн тайланд аймгийн нөөц бүрдүүлэхтэй холбоотой Амгалан Ховд ХХК -ийн 15.0 сая төгрөг, Дочим ХХК-ийн 70.0 сая төгрөг, Хүнс хөдөө аж ахуйн газрын 35.3 сая төгрөгийн он дамжин төлөгдөөгүй 120.3 сая төгрөгийн авлагыг бууруулах арга хэмжээг аваагүй байна.

2.36 Сумдын ЗДТГ-ууд нь өвс тэжээлийн орлогыг бүртгэлд бүрэн тусгаагүй, тооцоо нийлж авлагаар баталгаажуулаагүй нийтлэг зөрчил байна. Үүнд:

- ✓ Жаргалант, Зэрэг, Цэцэг, Чандмань, Эрдэнэбүрэн, Дуут, Алтай, Булган, Дарви, Буянт сумууд аймгийн ЗДТГ-аас хүлээн авсан өвс тэжээлийн тооцоо нийлж өглөг, авлагыг баталгаажуулаагүй,
- ✓ Манхан сум 2023 онд 50 хувиар хөнгөлж олгосон тэжээлийн авлагыг хөнгөлөөгүй дүнгээр бүртгэж тайлагнасан
- ✓ Мөнххайрхан сум 2023 онд үүссэн өвс тэжээлийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй,
- ✓ Жаргалант, Зэрэг, Цэцэг, Үенч, Мөст, Алтай, Дөргөн, Дуут, Дарви, Мянгад, Ховд, Эрдэнэбүрэн, Чандмань сумууд бэлтгэсэн өвс, тэжээлийг шууд зарлагдаж, авлагаар бүртгэж тайлагнаагүй, аймгийн аюулгүйн нөөцөөс өгсөн өвс тэжээлийг бүртгэлд тусгаагүй, тооцоо нийлээгүй
- ✓ Аймгийн ЗДТГ нь Тариалан эрхлэлтийн дэмжих сангаас олгосон 3 хадлангийн трактор, тоног төхөөрөмжийг түрээсэлсний төлбөрт ногдох өвсийг гэрээнд заасан хэмжээнээс 2023 онд 65.1 сая, 2024 онд 45.4 сая төгрөгийн өвсийг дутуу төвлөрүүлсэн,

2.37 Төсөв захирагч нь бэлтгэж байгаа нөөцийн бүрдүүлэлт, зарцуулалтад холбогдох журам болон гэрээнд заасны дагуу хяналт хэрэгжүүлэн ажиллаж байна.

2.38 Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журамд аймаг нийслэл дэх хүнсний хяналт хэрэгжүүлэх байгууллага болон мал амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан улсын байцаагч нь холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийнхээ дагуу тухайн бэлтгэсэн нөөцийн чанар аюулгүй байдал, баталгаажилт, гарал үүсэл, хадгалалт, тээвэрлэлтэд хяналт тавихаар журамласан.

2.39 Аймгийн Засаг дарга 2023, 2024 оны нөөцийн мах бэлтгэх үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсгийг холбогдох мэргэжлийн байгууллагуудын улсын байцаагч нарыг оруулан байгуулсан бөгөөд захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор ажлын хэсэг 6 удаа хяналт хэрэгжүүлсэн байна.

2.40 Харин өвс, тэжээлийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсгийг аймгийн Засаг даргаас байгуулж, 2023, 2024 онуудад батлагдсан удирдамжийн дагуу сумдад хяналт хэрэгжүүлэн, зөвлөмж өгч ажилласан байна.

2.41 Тариалан эрхлэлтийн дэмжих сангаас 2019 онд олгосон хадлангийн трактор, техник иж бүрдэл нийлүүлэх менежментийн гэрээний хэрэгжилт хангалтгүй, Хүнс хөдөө аж ахуйн газраас хяналт хэрэгжүүлээгүй, тоног төхөөрөмжийн үнийг бүрэн төлөөгүй байна.

2.42 Цэцэг сумын ЗДТГ-ын дотоод хяналт сул байгаагаас холбогдох албан тушаалтнууд өвс, тэжээлийн тооцоо бодоогүй, тайлан гаргаагүй, анхан шатны баримт бүрдүүлээгүй, ажлын чиг үүргээ хангалтгүй гүйцэтгэжээ.

2.43 Аймгийн Засаг дарга 2023 оны А/820 тоот захирамжаар шатахууны чанар стандартад нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, Засаг даргын зөвлөлд танилцуулахыг холбогдох албан тушаалтанд үүрэг болгосон ч хяналт хэрэгжүүлсэн талаар баримт байхгүй, Оюу мандал ХХК-тай байгуулсан шатахууны нөөц бүрдүүлэх ажлын гэрээний хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлээгүй байна

2.44 Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтад санхүү төрийн сангийн нэгж, төсвийн захирагч хяналт тавина гэж заасан ч хяналт хэрэгжүүлсэн талаар тайлан мэдээ байхгүй, хяналт сул байна.

Аудитаар нийт 2,305.4 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 65.9 сая төгрөгийн 8 төлбөрийн акт, 1,425.9 сая төгрөгийн 6 зөрчил арилгуулах албан шаардлага, 813.6 сая төгрөгийн алдаа зөрчилд 17 зөвлөмж өглөө.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Аймгийн нөөц бүрдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг төсөвт төлөвлөөгүй, худалдан авах ажиллагааг зохион байгуулахгүйгээр 452.8 сая төгрөгийн нөөц бэлтгэжээ.
2. Иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцээгүй, хугацаа дууссан тэжээл бэлтгэж төсвийн үрэлгэн зардал бий болгожээ.
3. Аймаг, сумдын ОНХС болон төслийн хөрөнгө оруулалтаар аймаг, сумуудын аюулгүйн нөөцийг хадгалах агуулахаар 90 хувь нь хангагдсан байна.
4. Иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн махны нөөц бэлтгэсэн ч нийлүүлсэн махны хэмжээ жилээс жилд буурснаар дэвшүүлсэн зорилтыг хангаагүй байна
5. Засаг даргын нөөц хөрөнгөд журамд нийцээгүй төсөвт төлөвлөх боломжтой зардлыг төлөвлөж санхүүжүүлсэн, бүртгэлээр тавих хяналт үр нөлөөтэй хэрэгжээгүй байна
6. Аймаг сумдын ЗДТГ нь бүрдүүлсэн нөөцийн авлага, өглөгийн тооцоо нийлээгүй, өмнөх онуудын 296.8 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжүүдийг өгч байна.

Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА М.АМАРСАНАА ТАНАА

1. Аймгийн нөөцөд мах бэлтгэхдээ Засгийн газрын 2023 оны 344 дүгээр тогтоолоор батлагдсан стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг мөрдөж, гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах.
2. Аймгийн нөөц бүрдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг орон нутгийн төсөвт тодорхой тусган ИТХ-аар батлуулах.
3. Аймгийн нөөцөд тэжээл бэлтгэхдээ худалдан авалтыг хууль журамд нийцүүлэн, үр дүнтэй зохион байгуулан ажиллах.
4. Засаг даргын нөөц хөрөнгийн журамд заасны дагуу зарцуулалтын тайланг гаргаж, зөвлөлийн хурлын тэмдэглэлийг бүрэн хөтөлж, зарцуулалтад хяналт хэрэгжүүлэн ажиллах.
5. Засаг даргын нөөц хөрөнгөөс урьдчилан төлөвлөх боломжтой хүндэт тэмдэг, одон медальтай холбоотой зардлыг санхүүжүүлэхгүй байх.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х.БААСАНХҮҮ ТАНАА

6. Өвс, тэжээлийн авлагын тооцоо нийлж, авлага барагдуулах арга хэмжээг үе шаттай зохион байгуулж, 2026 онд 40-өөс багагүй хувиар бууруулж ажиллах.
7. Бэлтгэсэн тэжээлийн зарцуулалт, хадгалалтад дотоод хяналтыг хэрэгжүүлэн эргэлтийг сайжруулж, төсвийн үргүй зардал гаргахгүй байх.
8. Бэлтгэж байгаа нөөцийг хүлээн авах ажлын хэсгийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, комиссын актыг иж бүрэн, үнэн зөв үйлдэж байх.

ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА Б.САНДАГСҮРЭН ТАНАА

9. Тариалан эрхлэлтийн дэмжих сангаас олгосон трактор, техник иж бүрдэл нийлүүлэх менежментийн гэрээний хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэн, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллах.

СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ

10. Жаргалант, Зэрэг, Цэцэг, Үенч, Мөст, Алтай, Дөргөн, Дуут, Дарви, Мянгад, Ховд, Эрдэнэбүрэн, Чандмань сумууд төсвөөс бэлтгэсэн болон аймгийн ЗДТГ-аас хүлээн авсан өвс, тэжээлийг бүртгэлд бүрэн тусгаж, өглөг авлагын тооцоо нийлж баталгаажуулан ажиллах.
11. Алтай, Чандмань, Зэрэг, сумууд бэлтгэсэн нөөцийн зарцуулалт, хадгалалтад дотоод хяналтыг хэрэгжүүлэн нөөцийн хугацаа дуусахаас өмнө эргэлтэд оруулах.
12. Булган сум холбогдох тушаал шийдвэргүйгээр үнэ төлбөргүйгээр өвс, тэжээлийг иргэдэд олгохгүй байх
13. Дуут сум 2024 онд борлуулсан 3.2 сая төгрөгийн өвс тэжээлийн орлогыг авлагаар бүртгэн төсөвт төвлөрүүлж ажиллах.
14. Ховд сум өвс, тэжээлийн агуулахын барилгыг стандартын шаардлагад нийцүүлэн шинэчилж, орчны нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах.
15. Манхан 2023 онд өвс, тэжээлийн авлагыг илүү бүртгэж тайлагнасан 2.9 сая төгрөгийн зөрчлийг залруулж зөв дүнгээр тайлагнах
16. Мөнххайрхан сумын ЗДТГ 2023 онд үүссэн өвс тэжээлийн авлагыг бүрэн барагдуулж, биотехник арга хэмжээнд бэлтгэсэн өвсийг сэлгэх арга хэмжээ авч, төсвийн үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.
17. Үенч сум 2023 онд төслийн санхүүжилтээр баригдсан агуулах, өвсний саравч, хашааг данс бүртгэлд тусгах арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу, зөвлөмжийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт 2026 оны 10 дүгээр сарын 20-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан аймгийн ЗДТГ-ын СТСХ, БОНХОБТХ, ХХААГ, МЭГ-ын хамт олонд талархал илэрхийлье.

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР